



Урлаг бол оюуны соёлын онцгой илрэл болох нь

Хамрах хүрээ: 9 анги




Урлаг гэж юу вэ?

- ❑ Соёлыг материаллаг ба оюуны гэж ангилдаг.
- ❑ Оюуны соёлыг илтгэдэг чухал хэлбэр нь **урлаг** юм.

Урлаг гэдэг нь





Өөрөөр хэлбэл урлаг бол уран бүтээлч хүний уран сэтгэмж, үзэл баримтлал, техникийн ур чадварыг илэрхийлсэн харааны, сонсголын бүтээл бүтээхэд чиглэсэн хүний төрөл бүрийн үйл ажиллагаа юм.

Харааны бүтээл



Сонсголын бүтээл



Beethoven - Moonlight Sonata - 2 Hours Version

The Best of Mozart

Chopin Spring Waltz 1 hours

Yiruma, (이루마) - Kiss the Rain

Жанцанноров - Цагаан суварга "Мөнхөд"

Урлаг нийгмийн амьдралд тодорхой үүрэг гүйцэтгэдэг

- ❑ Гоо сайхны үүрэг:
- ❑ Бие хүн төлөвшүүлэх үүрэг
- ❑ Танин мэдэхүйн үүрэг гэсэн үүргүүдийг гүйцэтгэнэ.

Урлаг нийгмийн амьдралд тодорхой үүрэг гүйцэтгэдэг

- Гоо сайхны үүрэг:

Бид урлагийн бүтээлийг үзэхдээ зөвхөн үйл явдал, агуулгыг ойлгох төдийгүй, сэтгэл хөдөлгөм, гайхалтай сайхан байдалыг зүрх сэтгэлээрэй мэдэрч байдаг. Бас жинхэнэ сайхныг төрхгүй, зохисгүй бүхнээс ялган салгаж, өөрийн үнэлэлт дүгнэлт өгөх чадвар эзэмшдэг байна.

Урлаг нийгмийн амьдралд тодорхой үүрэг гүйцэтгэдэг

□ Бие хүн төлөвшүүлэх үүрэг

Хүний төлөвшил, соёл, мөс чанар тэдгээрийн илрэл, үр дагаврыг урлагаар дамжуулан ойлгож, сайн сайхан өөд тэмүүлэх, муу муухайг жигшин зэвүүцэх дээд зэргийн мэдрэмжийг олж авдаг.

Супер хүн: - надад шударга ёс ба түүний төлөө үргэлж золиос байдаг гэдгийг ойлгуулдаг.

Икс-хүмүүс: надад хүмүүсийн зовлонг ойлгодог байх нь хичнээн чухал гэдгийг заадаг

Хүн аалз: Хүмүүст итгэл найдвар өгдөг гэх мэт

Ямар нэгэн уран сайхны кино үзлээ гэж бодъё. Кинонд үнэн төрхөө нууж гадна аа сайхан царайлсан хэн нэгэн хүн гарч байна. Энгийн амьдрал бол түүнийг муу хүн болохыг тийм богинохон хугацаанд (1цаг 30 минут) орчимд мэдэх бололцоогүй. Хэрвээ тэр кино жинхэн уран сайхны үнэ цэнэтэй бүтээл мөн бол үйл явдлаараа үзэгчдийг итгүүлэн татаж чадна.


Тэгээд муу дүрийг буруутгах үзлийг тээсээр хохирч буй шудрага дүрийг өрөвдөн хайрласаар үзэгчид киног дуусгана. Ийм дүрийн тухай эргэцүүлснээр амьдрал дээр ч тийм хүн хэн болохыг мэдэж хүний амьдралын утга учир үнэ цэнийн тухай бодож эргэцүүлэх гэх мэтээр өөрийн үнэлэлт дүгнэлтээ хийж байдаг.

Урлаг нийгмийн амьдралд тодорхой үүрэг гүйцэтгэдэг

- Танин мэдэхүйн үүрэг

Нийгэм хүний амьдралын нарийн төвөгтэй үйл явдлуудын талаар мэдээлэл түгээдэг үнэ цэнтэй эх сурвалж бол уран бүтээл юм. Урлагийн судлагдахуун нь цаг ямагт хүн байсаар иржээ. Уран бүтээл нь тухайн цаг үедээ шүүмжлэлтэй хандах ирээдүйн тухай таамаг дэвшүүлэх чадварыг олгодог.

Үндэстний соёл урлагийг хэн бүтээж байна
ямар түвшний соёл байна гэдгээс хамаарч
гурван хэлбэрт ялгадаг.



Ардын соёл

- ❑ Морин хуур, уртын дуу зөвхөн монгол туургатанд байдаг шиг ардын соёл нь зөвхөн тухайн үндэстний гэж хэлж болох соёлын хэлбэр юм. Ардын соёлыг ардын билиг авьяастнууд бүтээдэг.
- ❑ Ардын соёл гарал үүслийн хувьд соёлын бусад хэлбэрээс түрүүнд үүссэн соёл юм.



Сонгодог соёл

□ Сонгодог соёлыг мэргэжлийн уран бүтээлчид бүтээдэг. Ийм учраас түүнийг хүлээн авах, ойлгоход зохих бэлтгэл хэрэгтэй. Уран зураг, уран барилга, найрал хөгжим, симфони, дуурь, бүжгийн жүжиг зэрэг нь сонгодог соёлын төрөл юм.

□ Хүн амын боловсрол соёлын түвшин дээшлэхийн хэрээр сонгодог соёлыг хэрэгчлэгчдийн хүрээ тэлж зөвхөн мэргэжлийн хүрээнийхнээр хязгаарлагдахаа больдог.



Нийтийн соёл

- ❑ Нийтийн соёл бол соёлын хамгийн хүртээмжтэй хэлбэр юм. Мэдээллийн хэрэгсэл дэлхийн ихэнх оронд нэвтэрсэн үе буюу ХХ зууны дунд үед үүссэн гэж үздэг.
- ❑ Нийтийн соёл олон улсын бас үндэстний шинжтэй байж болно.
- ❑ Бусад хэлбэрийг бодвол хамгийн олон үзэгчидтэй.

- ❑ Нийтийн соёлын хэлбэрүүд поп, хит дуу, страдын урлаг(олон улсын соёлын хэлбэрт орж болно) зэрэг орно оо.
- ❑ Нийтийн соёл нь зохиогчтой байхын зэрэгцээ хүмүүсийн тухайн агшны эрэлтийг хангаж аливаа шинэ үйл явдлыг тусгаж байдаг



Цахим орчин дахь харилцааны соёл

Орчин цагт цахим хэрэглээ нь харилцааны гол хэлбэр болж байна. Интернет сүлжээ нээснийг судлаачид зарим тохиолдолд газар зүйн эх нээлттэй харьцуулах нь бий.

Цахим харилцаа нь эерэг болон сөрөг үр дагавартай байж болно.

Цахим харилцааны эерэг нөлөө

- ❑ Хурдан хугацаанд мэдээлэл авах, ашиглах, түгээх,
- ❑ Бусадтай санал солилцох
- ❑ Сурах мэдлэг боловсролоо дээшлүүлэх
- ❑ Банк, эрүүл мэнд болон бусад салбарын үйлчилгээг авах
- ❑ Мөн сурч мэдэхийг хүсч буй хүн бүрийн заавал эзэмших соёл болоод байна.

Цахим харилцааны сөрөг нөлөө

- ❑ Цахим орчин дахь хэрэглэгээр нь хэн нэгнийг зохистой, зохисгүй, хөдөлмөрч эсвэл төрхгүй бүдүүлэг гэх мэтээр дүгнэх бүрэн боломжтой болжээ.
- ❑ Зарим улс оронд цахим хэрэглээний сөрөг нөлөөллөөс хүүхэд олон нийтийг хамгаалах хууль дүрэм боловсруулсан байдаг.

Цахим харилцаанд соёлтой оролцоно гэдэг нь

Дараах хэм хэмжээг сахих хэрэгтэй юм.

- Мэдээллийг ямар ч хяналтгүйгээр ашиглахгүй байх.
- Өөрт ямар ч ач холбогдолгүй мэдээ уншиж олон цагаар интернетэд сууж үнэтэй цагаа барахгүй байх.
- Нүүр номд хичнээн цаг зарцуулж байгаагаа хянадаг мэддэг байх.
- Хэн нэгнийг санаатайгаар доромжлох нэр төрд нь халдах хуурамч мэдээлэл тараахгүй байх.
- Цахим хэрэглээгээр дамжиж буруу зүйлд уруу датагдахаас зайлсхийх
- Нууц нэрээр хаяг нээх, юу дуртайгаа бичих, бүдүүлэг үг хэллэг хэрэглэхгүй байх.
- Цахим орчинд хэнтэй найз байх ямар зүйл нийтлэх талаар өөртөө шөөрдлөгө тавьдаг байх

Бататгал

- ❑ Сонгодог болон ардын соёл нь харьцангуй тогтвортой шинжтэй.
 - ❑ Нийтийн соёл нь шинэлэг байдлаа түргэн алдаж хуучирч болно.
 - ❑ Ардын соёл бол анхдагч
 - ❑ Урлаг нь гурван үүрэгтэй.
 - ❑ Цахим орчинд зөв боловсон байх шаардлагатай
-
- Уншиж ойлгоод дэвтэртээ тэмдэглээд сурах бичгийн дасгал даалгаврыг гүйцэтгээд assignment рүү явуулаарай. Сурах бичиг хуудас: 38